

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

2018-06-11

Улаанбаатар хот

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

“Авто замын сан” /Төлбөр авах цэг/-гийн
2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн шалгалтын тухай

Нэг.ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсээс “Авто замын сан” /Төлбөр авах цэг/-ийн 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай, Авто замын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн акт бусад холбогдох дүрэм журмыг удирдлага болгон тэдгээрийн мөрдөлт хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

Шалгалтаар “Төлбөр авах цэг” /Авто замын сан/-ийн шалгагдсан хугацааны мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын баримт, цалин хөлсний болон үндсэн хөрөнгө, бараа материал, үнэт цаасны тооцоо, хадгалалт хамгаалалт, төсвийн мэдээ, тайлан тэнцлийн гаргалт, Зам тээврийн хөгжлийн төвийн захирлын гэрээт ажилтнуудтай байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”, тушаал, шийдвэр болон Замын сангийн давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүн, бусад байгууллага хүмүүстэй хийсэн гэрээ хэлэлцэл болон холбогдох бусад баримтыг хамруулан шалгав.

Шалгалтыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Гэрэл, улсын байцаагч С.Баттөр нар хийж гүйцэтгэлээ.

“Төлбөр авах цэг” /Авто замын сан/-ийн шалгалтад хамрагдсан хугацааны санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримтанд гарын үсгийн нэгдүгээрийг 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл Зам тээврийн хөгжлийн төв /ТӨҮГ/-ийн Захирал Б.Мандат,

2016 оны 10 дугаар сарын 13-ний өдрөөс Р.Буд, гарын үсгийн хоёрдугаарыг 2017 оны 3 дугаар сарын 01 хүртэл Нягтлан бодогч Л.Чимгээ, 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс З.Золжаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлсэн байна.

Мөн Төлбөр авах цэгийн давсан орлогыг зарцуулах эрхийн нэгдүгээр гарын үсгийг Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Сайдын багцын ерөнхий нягтлан бодогч Ч.Ренчиндамба нар зурж захиран зарцуулсан байна.

Төлбөр авах цэгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Юнистар-Аудит ХХК хөндлөнгийн аудит хийж “Төлбөр авах цэг /Замын сан/-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн бодиттой илэрхийлсэн, Үндэсний аудитын газраас Зам тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчилгүй санал дүгнэлтийг тус тус өгсөн байна.

Зам тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2016 оны 5 дугаар сард Төлбөр авах цэг /замын сан/-ийн 2014, 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, 5 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл:

Монгол улсын Засгийн газрын тусгай сангийн хуулинд:

6.1.Тусгай сан дараахь ангилалд хуваана:

6.1.1. тусгай хуулиар зохицуулах сан;

6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна:

6.2.4. *Улсын авто замын сан* гэсний дагуу Авто замын сан нь “Авто замын тухай хууль”-иар зохицуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.Олон улс, улсын болон нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалт бүхий “Авто замын сан”-тай байна, 24 дүгээр зүйлийн 24.6. “Улсын авто замын сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын,,,,,,мэдэлд байна.” гэж заасны дагуу

Зам тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Төлбөр авах цэг /Авто замын сан/ нь Зам тээрийн хөгжлийн төв /ТӨҮГ/-ийн Төлбөр авах нэгж, хөдөлгөөний хэлтэсийн статусаар үйл ажиллагаагаа явуулж байна. Төлбөр авах нэгжийн үйл ажиллагааны чиглэл нь ТӨХ-ны 2015 оны 220 дугаар тогтоол, Сангийн сайдын ЗТХТ “ТӨҮГ”-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн тогтоох тухай” 2016 оны 207 тоот тушаалаар батлагдсан Зам тээврийн хөгжлийн төв /ТӨҮГ/-ын дүрмээр зохицуулагдаж байна.

Авто замын тухай хуулийн 25.1.Улсын авто замын сангийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

25.1.1.импортоор оруулж байгаа авто машины онцгой албан татварын 20-иос доошгүй хувь;

25.1.2.гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгө;

25.1.3.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

25.1.4.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр;

25.1.5.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;

25.1.6.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс авах төлбөр, хураамж;

25.1.7.авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр;

25.1.8.бусад.

Авто замын сан нь дээрх эх үүсвэрүүдээс бүрдэхээр зааснаас 25.1.4 заалтыг хэрэгжүүлэн Төлбөр авах цэгээр дамжуулан улсын авто Замын санг бүрдүүлж, орлогыг улсын төсөвт 100 хувь төвлөрүүлж байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 106, 2016 оны 103 дугаар тогтоолоор Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээг тогтоосон байна.

Зам тээврийн хөгжлийн сайдын “Журам, шинэчилсэн орлогын төлөвлөгөө, бүтэц, орон тоо батлах тухай” 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 57 тоот тушаалаар “Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах цэгийн зохион байгуулалт, орлогыг төвлөрүүлэх, зарцуулах үйл ажиллагааны журам”-ыг баталсан байна.

Замын сан /Төлбөр авах цэг/ нь Төрийн сан дахь 100900028054 тоот дансанд замын хураамжийн орлогыг төвлөрүүлэн, ЗТЯ-ны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан үйл ажиллагааны урсгал зардлын санхүүжилтийг хуваарийн дагуу олгон, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргасан байна.

Замын сангийн үйл ажиллагааны зардлын төсөв ЗТСайд, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад батлагдан, 2016 онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд нийт дүнгээр нь, 2017 онд зардлын ангиллаар баталсан байна.

Тус сан нь Зам тээврийн хөгжлийн төвийн ХААН банкны 5013170948 тоот харилцах дансаар урсгал зардлын үйл ажиллагаагаа явуулж, төсвийн санхүүгийн тайланг ЗТЯ-д гарган өгсөн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 130 тоот тушаалаар авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг зохион байгуулах эрхийг Зам тээврийн хөгжлийн төв /ТӨҮГ/-д даалгасаны дагуу хэрэгжүүлж байна.

Тус сангийн удирдлагыг Зам тээврийн хөгжлийн төв /ТӨҮГ/-ийн захирал хэрэгжүүлж, тус сангийн орон тоо, орлого, зардлын төсвийг тушаалаар батлан, 2016 онд батлагдсан Төлбөр авах 15 цэгт 111 ажилчид, захиргааны 5 албан хаагч нийт 116, 2017 онд Төлбөр авах 19 цэгт 130, захиргааны 8 нийт 138 орон тоогоор тус тус ажиллажээ. Төлбөр авах цэгийн ажилтан албан хаагчид нь ЗТХТөв /ТӨҮГ/-ийн захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Гурав. Төсвийн орлогын бүрдүүлэлт, зардлын гүйцэтгэлийн талаар

3.1. Төсвийн орлого

Төлбөр хураах цэг нь 2016 онд нийт 4,800.0 сая төгрөгийн орлого төлөвлөсөнөөс 4,969,7 сая төгрөгийн, 2017 онд 5,300.0 сая төгрөгийн орлого төлөвлөсөнөөс 7,006.9 сая төгрөгийн орлогыг оруулж төлөвлөгөөг 103.5-132.0 хувиар биелүүлсэн байна.

/ сая төгрөг/

Үзүүлэлт	2016 он		2017 он	
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үндсэн үйл ажиллагааны орлого	4,800.0	4,969.7	5,300.0	7,006.9
Үйл ажиллагааны зардал	1,919.9	1,630.5	1,934.1	1,846.1
Улсын төсөвт төвлөрүүлсэн		3,339.3		5,160.8

Замын санд Төлбөр авах цэгээр дамжуулан авто замын ашиглалтын хураамжийн орлогыг авч улсын төсөвт 100 хувь төвлөрүүлж, 2016 онд Төлбөр авах 18 цэгээс 4,969.7 сая төгрөг, 2017 онд Төлбөр авах 19 цэгээс 7,006.9 сая төгрөгийн орлогыг оруулжээ.

Төлбөр авах цэгүүдийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

	/мянган төгрөгөөр/	
Төлбөр авах	2016 он	2017 он

	цэгийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар
1	Рашаант	790,000.0	811,182.2	102.7	790,000.0	975,945.2	123.9
2	Налайх-Тэрэлж	10,000.0	420,154.0	102.5	410,000.0	588,808.2	143.6
3	Хоолтын	80,000.0	501,438.4	104.5	460,000.0	688,070.5	149.0
4	Хэрлэнгийн гүүр	160,000.0	163,764.1	102.4	130,000.0	236,295.0	181.7
5	Өлзийтийн	330,000.0	367,573.9	111.4	350,000.0	489,930.0	140.0
6	Замын-Үүд	480,000.0	491,696.9	102.4	400,000.0	509,906.5	127.48
7	Дулаанхаан	300,000.0	345,791.1	115.3	330,000.0	436,777.0	132.4
8	Дархан	470,000.0	470,343.2	100.1	460,000.0	558,177.0	121.3
9	Хангалын гүүр	390,000.0	396,069.5	101.6	380,000.0	512,892.0	134.9
10	Гуртын гүүр	105,000.0	113,691.4	108.3	100,000.0	158,816.2	158.8
11	Ганц мод	200,000.0	215,107.5	107.6	190,000.0	279,501.0	147.1
12	Хархорин	200,000.0	235,757.0	117.9	210,000.0	306,801.6	146.1
13	Онгийн гүүр	180,000.0	206,172.8	114.5	180,000.0	271,194.5	150.6
14	Түйн гүүрийн	70,000.0	79,938.9	114.2	65,000.0	106,198.0	163.4
15	Хандгайтын	60,000.0	70,709.5	117.9	65,000.0	78,006.5	120.0
16	Айраг	60,000.0	24,235.9	40.4	320,000.0	367,803.2	114.9
17	Мандалговь	40,000.0	34,155.0	85.4	180,000.0	332,066.1	184.5
18	Ховдын Булган	35,000.0	0.0	0.0	130,000.0	11,279.0	8.7
19	Баруун-Урт	40,000.0	12,234.0	30.6	150,000.0	84,890.0	56.6
20	Бусад		9,732.8		0.0	13,564.3	
	Дүн	4,800,000.0	4,969,748.1	103.5	5,300,000.0	7,006,921.8	132.0

Төлбөр авах цэгүүд нь 2016-2017 онд орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн ч Мандалговь, Баруун-Урт, Айрагийн ТАЦ-ийн байр шинээр барьж 2016 оны 10 дугаар сард ашиглалтад оруулах байсан боловч хугацаандаа ороогүй, Ховдын Булганы ТАЦ-ийн байр баригдсан боловч цахилгаан дамжуулах агаарын шугам барих хөрөнгийн асуудал шийдэгдэлгүй 2017 онд санхүүжилт олгогдсон, Баруун-Уртын ТАЦ-ийн хөдөлгөөний эрчимийг өндрөөр тогтоож төлөвлөсөн, 2017 онд Булганы ТАЦ шинээр ашиглалтанд орсон боловч Баруун хил рүү чиглэсэн өөр замтайгаас шалтгаалж хөдөлгөөний эрчим бага байснаас тус цэгийн орлого тасарсан байна.

Дээрх байдлаас харахад ТАЦ-ийн орлогыг төлөвлөхдөө хөдөлгөөний эрчимийг бодитой судалж уялдуулан төлөвлөх нь зүйтэй байна.

Бусад орлогоор 2016 онд 9,732.8 сая төгрөг, 2017 онд 13,564.0 сая төгрөг олсон нь Төлбөр авах цэгүүдээр өдөрт олон удаа нэвтрэх тээврийн хэрэгслийн замын төлбөрийн зохих хувийг хөнгөлөн гэрээ байгуулан оруулсан орлого байна. Дээрх хөнгөлөлтийн төлбөрийн журмыг ЗТХТ-ийн захирлын тушаалаар батлан мөрдөж байна.

3.2 Үйл ажиллагааны зардлын төсөв, гүйцэтгэлийн талаар

Төлбөр авах цэг /Авто замын сан/-ийн үйл ажиллагааны зарлага, санхүүжилтийг ЗТЯ-ны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна. Тус

сангийн урсгал зардалд улсын төсвөөс 2016 онд 1,919.9 сая төгрөг батлагдсанаас 1,325.9 сая төгрөг, 2017 онд 1,934.1 сая төгрөг батлагдсанаас 1,834.1 сая төгрөгийн зардал гарган ажиллажээ.

Замын сангийн 2016-2017 оны төсвийн гүйцэтгэлийг харуулбал:

/мянган төгрөг/

Зардлын ангилал	2016 он			2017 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү (-) хэмнэлт(+)	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү (-) хэмнэлт(+)
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	1,919,961.9	1,325,972.8	593,989.1	1,934,062.4	1,846,106.2	87,956.2
Ажиллагсадтай холбоотой зардал	1,651,120.0	988,900.7	662,219.3	1696526.1	1652681.9	43,844.20
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,432,757.5	845,512.5	587,244.9	1,528,402.0	1,492,968.2	35,433.8
НДШ	218,362.50	143,388.10	74974.4	168,124.1	159,713.7	25,179.4
Бараа үйлчилгээний бусад зардал	268,841.9	337,072.1	(45,855.0)	237,536.2	193,424.4	44,111.8
Гэрэл, цахилгаан	37,966.0	37,486.4	479.6	40,300.0	32,486.5	7,813.5
Түлш, халаалт	11,000.0	7,654.4	3,345.6	11,500.0	11,487.8	12.2
Бичиг хэрэг	4,255.0	3,425.1	829.9	4,800.0	4,800.0	-
Тээвэр (шатахуун)	61,550.0	63,226.3	(1,676.3)	50,800.0	50,796.4	3.6
Шуудан, холбоо	3,920.0	3,460.0	460.0	4,560.0	4,540.0	20.0
Жижиг эд хогшил худалдан авах (Бага үнэ түргэн элэгдэл зүйлс)	13,900.0	15,811.0	(1,911.0)	6,240.0	6,239.5	0.5
Нормын хувцас	15,600.0	25,183.0	(9,583.0)	16,200.0	13,271.0	2,929.0
Багаж, техник, хэрэгсэл		10,667.0	(10,667.0)	8,700.0	8,700.0	-
Дотоод албан томилолт	10,900.0	18,621.4	(7,721.4)	8,500.0	8,500.0	-
Бусад нийтлэг үйлчилгээ	57,561.9	39,452.3	18,109.6	9,500.0	9,468.7	31.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	360.0	405.0	(45.0)	360.0	360.0	-
Банкны үйлчилгээний хураамж	780.0	708.7	71.4	900.0	898.3	1.7
Маягт хэвлүүлэх зардал	15,500.0	16,650.5	(1,150.5)	18,000.0	18,000.0	-
Бараа ажил үйлчилгээний бусад зардал	9,074.0	33,631.2	(24,557.2)	23,876.2	23,876.2	-
Нэг удаагийн тэтгэмж	13,200.0	25,039.6	(11,839.6)	33,300.0	-	33,300.0
Урсгал засвар	13,275.0	14,980.1	(1,705.1)			
Тавилга		7,550.0	(7,550.0)			
Аудитын төлбөр		13,120.0	13,120.0			

Замын сан нь шалгагдсан онуудад зардлыг нийт дүнгээр 593.9-87.6 сая төгрөгөөр хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

2016-2017 онд нийт зардлын 74.6-80.8 хувийг цалингийн зардал эзэлж байна.

Тус сангийн үйл ажиллагааны зардлыг 2016 онд ЗТХСайдын төсвийн багцад Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд нийт дүнгээр нь баталсан ч сангаас сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг зардлын ангиллаар гарган тайлагнажээ.

Дөрөв. Өр, авлагын талаар

Авлага:

Авто замын сан нь 2016 оны жилийн эцэст 3,179.0 сая төгрөгийн авлагатай гарч, 2017 оны жилийн эцэст 0.4 сая төгрөг болж авлага буурсан байна.

Авто замын сангийн 2016-2017 оны авлагыг задалж харуулбал:

/сая төгрөг/

Үзүүлэлт	2016 он			Эцсийн үлдэгдэл	2017 он		
	Эхний үлдэгдэл	нэмэгдсэн	хорогдсон		нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Байгууллага	4,464.7	3,339.3	4,624.9	3,179.0			
Бусад					0.9	0.5	0.4
Нийт дүн	4,464.7	3,339.3	4,624.9	3,179.0	0.9	3,179.5	0.4

Замын сан нь 2016 оны эцэст 3,179.0 сая төгрөгийн авлагатай гарсан нь 2015 онд улсын төсөвт төвлөрүүлсэн төлөвлөгөөнөөс давсан орлогыг Сангийн яамнаас буцаан авах авлагатай гарсаныг 2017 онд Сангийн яамнаас буцаан олгосон байна. 2017 оны эцэст 421.3 мянган төгрөгийн авлагатай гарсан нь ажилчидтай холбоотой авлага байна.

ТАЦ /Замын сан/ нь шалгагдсан онуудад өглөггүй гарсан байна.

Тав. Өмч хөрөнгийн талаар

5.1 Үндсэн хөрөнгө

Төлбөр авах цэг нь 2016, 2017 оны төсвийн жилд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу үндсэн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, тооцоог бодож, үр дүнг баталгаажуулах, хөрөнгө оруулалтын үр дүнд шинээр худалдан авсан хөрөнгийг зохих журмын дагуу орлогод авч, данс бүртгэлд тусган бүртгэж тайлагнаж ажилласан байна. Авто замын сан нь нийтдээ 2016 онд 2,136.2 сая төгрөгийн, 2017 онд 2,374.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон байна.

Замын сан /Төлбөр авах цэг/-ын үндсэн хөрөнгийн хөдлөлийг харуулбал:

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2016			2017			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	961,142,783	861,656,489	-	1,822,799,272		-	1,822,799,272
2	Авто мээврийн хэрэгсэл			-	-	237,725,158	-	237,725,158
3	Тоног төхөөрөмж	220,107,200	60,482,500	-	280,589,700		-	280,589,700
4	Тавилга хэрэгсэл	22,133,950	7,550,000	-	29,683,950	717,000	-	30,400,950
5	Программ хангамж	3,135,500		-	3,135,500		-	3,135,500
				-	-		-	-
	НИЙТ ДҮН	1,206,519,433	929,688,989	-	2,136,208,422	238,442,158	-	2,374,650,580

2016 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос эрх нээлгэн санхүүжүүлсэн Ховдын Булган, Дорноговийн Айраг, Сүхбаатарын Баруун-Урт, Дундговийн Мандалговьд Төлбөр авах цэгийн байр шинээр барин 304.5 сая төгрөгийн хөрөнгийг дансанд бүртгэсэн байна.

Хандив тусламжаар 557.2 сая төгрөгийн хөрөнгийг дансанд авч, 68.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг урсгал үйл ажиллагааны зардлаас худалдан авч дансанд бүртгэжээ.

2017 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 241 дүгээр тогтоолоор “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 237.7 сая төгрөгийн үнэтэй, 186.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 51.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 6 ширхэг автомашиныг Авто замын сан /Төлбөр авах цэг/-гийн үндсэн хөрөнгөнд балансаас балансад шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгасан байна. Эдгээр автомашиныг орон нутгийн Төлбөр авах цэгүүд ашиглаж байна.

2016 онд 68.0 сая төгрөгийн, 2017 онд 0.7 сая төгрөгийн, нийт 68.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр худалдан авч бэлтгэн, данс бүртгэлд тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

5.2 Үнэт цаасны талаар

Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 103 дугаар тогтоолоор “Олон улсын болон улсын чанартай зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээг” шинэчлэн тогтоосон байна.

Тээврийн хэрэгслээс авах тогтоосон төлбөрийн хэмжээг харуулбал:

Тээврийн хэрэгслийн төрөл	Ангилал	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
Зорчигч тээврийн хэрэгсэл	12 хүртэл хүний суудалтай	1 000
	12-24 хүний суудалтай	2 000
	24-өөс дээш хүний суудалтай	3 000
Ачаа тээврийн хэрэгсэл	2 тэнхлэгтэй 3.5 тн хүртэл бодит жинтэй	2 000
	2 тэнхлэгтэй 3.5-18 тн хүртэл бодит жинтэй	3 000
	3 тэнхлэгтэй 18 тн хүртэл бодит жинтэй	4 000
	3 тэнхлэгтэй 18-25 тн хүртэл бодит жинтэй	5 000
	4-өөс дээш тэнхлэгтэй 25 тн хүртэл бодит жинтэй	6 000
	4-өөс дээш тэнхлэгтэй 25 тн-оос дээш бодит жинтэй	10 000
Бусад	Механизм	10 000
	Мотоцикл	500

Авто замын сангийн Төлбөр авах цэгүүдэд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн үнэт цаасны /тасалбар/ нэг бүрийн анхны өртөгийг 3.5 төгрөг байхаар “Мөнхийн үсэг” ХХК-тай гэрээ байгуулан авсан байна.

2016 онд 4 383 286 ширхэг буюу 15,341.5 мянган төгрөгийн, 2017 онд 5 605 776 ширхэг буюу 19,620.2 мянган төгрөгийн үнэт цаасыг тус тус зарцуулж, ТАЦ-ийн ахлагч нартай тооцоог хийж тайлан гаргаж ажилласан байна. /Хүснэгт - 1, 2/

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 103 дугаар тогтоолоор “Олон улсын болон улсын чанартай зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах

төлбөрийн хэмжээг” шинэчлэн тогтоосны дагуу төлбөр авах цэгүүдэд 2016 онд 4,383,286 ширхэг үнэт цаас зарцуулж 5,054,032.1 мянган төгрөгийн, 2017 онд 5,605,776 ширхэг үнэт цаас зарцуулж 7,477,995.0 мянган төгрөгийн орлого олж ажилласан байна. /Хүснэт - 3, 4/

Зургаа. Нэмэлт орлогоос олгосон санхүүжилт, зарцуулалтын талаар

Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын хураамжийн улсын төсөвт оруулсан төлөвлөгөөнөөс давсан орлогоос Сангийн сайдын тушаалаар Замын сангийн Төрийн сан дахь орлогын дансанд санхүүжилтийг олгон, Авто замын тухай хуулинд заасны дагуу авто замын засвар, арчлалт, төлбөр авах цэгийн байр барих, урсгал засвар хийх, тоног төхөөрөмж, эд хогшил авахад зарцуулагджээ.

Нэмэлт орлогоос олгосон санхүүжилтийн зарцуулалтыг гаргаж тайлагнасан байна.

Шалгагдсан онуудад улсын төсөвт төвлөрүүлсэн төлөвлөгөөнөөс давж биелэсэн орлогыг Сангийн яамнаас ЗТХЯамны Авто замын сангийн Төрийн сангийн орлогын харилцах дансанд оруулж, уг санхүүжилтийг Зам тээврийн хөгжлийн яамнаас салбарын сайдын баталсан тушаалын дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна. Үүнд:

2016 онд олгосон санхүүжилт, зарцуулалт:

- Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 26-ны “Төсвийн урамшуулал олгох тухай” 163 тоот тушаалаар 2014 оны үйл ажиллагааны нэмэлт орлогоос байгууллагад олгох зардлаас санхүүжүүлэхийг Төрийн сангийн газарт даалган, Замын сан /Төлбөр авах цэг/-д 3,531,7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 304.5 сая төгрөг олгогдсон байна.

Дээрх тушаалын дагуу Зам тээврийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 62 тоот тушаалаар 330.0 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсанаас гүйцэтгэлээр 305.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх жагсаалтын 1 дүгээрт заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Сүхбаатар аймгийн Засаг дарга /Ж.Батсуурь/-д, жагсаалтын 2, 3 дугаарт заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Д.Мандат/-т шилжүүлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянан баталгаажуулан хяналт тавин ажиллахыг тус тус даалгасан байна.

/МЯН.ТӨГ/

	Төсөл, арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гэрээ-ний дүн	Гүйцэтгэл дүн	Худалдан авалтын төрөл	Гүйцэтгэгч байгууллага
1	A2001 дугаартай Өндөрхаан-Баруун-Урт чиглэлийн замд барих төлбөр хураах цэгийн барилга, цахилгаан хангамж, авто замын өргөтгөлийн ажил /Сүхбаатар аймаг/	230,000.0	208,800.0	208,800.0	Нээлттэй	"Норкут" ХХК
2	A0102 дугаартай Чойр-Сайншанд чиглэлийн замд шинээр барьсан төлбөр хураах цэгийн цахилгаан хангамжийн ажил /Дорноговь аймаг/	50,000.0	48,158.9	48,158.9	Харьцуулалт	"Чингүүд" ХХК
3	A0201 дугаартай УБ-Мандалговь чиглэлийн замд шинээр барьсан төлбөр хураах цэгийн цахилгаан хангамжийн ажил /Дундговь аймаг/	50,000.0	49,278.7	48,233.7	Харьцуулалт	"БЗӨБЦТС ТӨХК"-ий харьяа Дундговь ЦТС салбар
	Нийт	330,000.0		305,237.6		

- A2001 дугаартай Өндөрхаан-Баруун-Урт чиглэлийн замд барих төлбөр хураах цэгийн барилга, цахилгаан хангамж, авто замын өргөтгөлийн ажлын гүйцэтгэлийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 03/830, 2016 оны 03/1945 дугаартай санхүүжилт хүсэх тухай албан тоотуудаар Сангийн яаманд хүргүүлэн, санхүүжилтийн эрх нээлгэн Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Төрийн сан дах 120051405 дансанд шилжүүлсэн байна.

Дээрх ажлын сонгон шалгаруулалтыг Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба зохион байгуулсан байна.

- A0102 дугаартай Чойр-Сайншанд чиглэлийн замд шинээр барьсан төлбөр хураах цэгийн цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэлийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын санхүүжилт 2016 оны 02/2977 дугаартай санхүүжилт хүсэх тухай албан тоотууд Сангийн яаманд хүргүүлэн, санхүүжилтийн эрхээ нээлгэн "Чингүүд" ХХК-ийн хаан банкны 5360118766 дансанд шилжүүлсэн байна.

Сонгон шалгаруулалтыг Зам, тээврийн хөгжлийн төвийн даргын 2016 оны 74 дүгээр тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо зохион байгуулсан байна.

- A0201 дугаартай УБ-Мандалговь чиглэлийн замд шинээр барьсан төлбөр хураах цэгийн цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэлийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 02/2976 дугаартай санхүүжилт хүсэх тухай албан тоотууд Сангийн яаманд хүргүүлэн, санхүүжилтийн эрхээ нээлгэн "БЗӨБЦТС" ТӨХК-ийн Дундговь салбарын хаан банкны 5450032465 дансанд шилжүүлсэн байна.

Сонгон шалгаруулалтыг Зам, тээврийн хөгжлийн төвийн даргын 2016 оны 74 дүгээр тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо зохион байгуулсан байна.

2017 онд олгосон нэмэлт санхүүжилт, зарцуулалт

Замын сангаас улсын төсөвт 2015-2017 онуудад төвлөрүүлсэн орлогоос нийт 9,409.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг санд буцаан олгожээ. Үүнд:

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 140 дүгээр тогтоолын 1-д “Төв аймгийн Зуунмод сумын төвийн Зуунмод багийн 3.5 км, Баянхошуу багийн 2.5 км хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажилд шаардагдах 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны нэмэлт орлогот зохицуулалт хийж шийдвэрлэхийг Сангийн сайдад, тушаалын 2-т дээрх ажлын нийт төсөвт өртгийн үлдэгдэл 1,549.9 сая төгрөгийг 2018 оны төсвийн төсөлд тусган шийдвэрлэхийг Сангийн сайд, ЗТХСайдад тус тус даалгасан.

- Сангийн сайдын 2017 оны 182 тоот тушаалаар 2016 оны төлөвлөгөөнөөс давсан орлого 3,339.3 сая төгрөгийг буцаан олгох шийдвэр гарсаны дагуу 2017 оны 7 дугаар сарын 6-ны өдөр сангийн дансанд орж иржээ.

- Сангийн сайдын 2016 оны 5 дугаар сарын 20-ны “Дансны үлдэгдэл буцаан олгох тухай” 195 тоот тушаалаар 2015 оны давсан орлого 1,571.7 сая төгрөгийг буцаан олгохоор батлагдан, тус санхүүжилт 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдөр сангийн дансанд орсоноос дараах арга хэмээнүүдэд зарцуулжээ.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 87 тоот тушаалаар Төлбөр авах цэгийн /Замын сан/-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс давсан орлогоос 76.8 сая төгрөг,

- 2017 оны 7 дугаар сарын 31-ны “Жагсаалт батлах, эрх шилжүүлэх тухай” 147 тоот тушаалаар Олон улс, улсын чанартай авто замын “Төлбөр авах цэг”-ийн 2015, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс давсан орлогоос 4,834.2 сая төгрөг, нийт 4,911.0 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсаны дагуу, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжүүлэн нийт 4,852.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ.

2017 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг хүснэгтээр харуулбал:

					/мян.төг/
Төсөл, арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Гүйцэтгэлийн дүн	Гүйцэтгэгч байгууллага	Худалдан авалтын төрөл
A0501 дугаартай УБ-Чингис чиглэлийн замд байрлах Налайх-Тэрэлжийн төлбөр хураах цэгийн дэргэдэх хяналт зохицуулалтын байрны засвар шинэчлэлтийн ажил	36,667.3	32,939.2	32,367.3	“Бэлчир” ХХК	Харьцуулалт
A0101 дугаартай УБ-Чойр чиглэлийн замд байрлах Хоолтын төлбөр хураах цэгийн дэргэдэх хяналт зохицуулалтын байрны засвар шинэчлэлийн ажил	40,147.9	39,849.1	39,151.1	“Өргөнгөв” ХХК	Харьцуулалт
Дүн /2016 оны 87 тоот тушаалаар/	76,815.2	72,788.3	71,518.4		
Төв аймгийн Зуунмод сумын					

төвийн Баруун Зуунмод багийн 3.5 км, Баянхошуу багийн 2.5 км хатуу хүчилттай авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил/Төв аймагт эрх шилжүүлсэн/	3,300,000.0	4,838,487.9	3,300,000.0	“Төв-А33А” ТӨХК	Шууд гэрээ
Олон улс болон улсын чанартай авто замуудад хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгаа хийх ажлын зардал	116,970.0	116,970.0	116,970.0	Зам тээврийн хөгжлийн төв	Шууд гэрээ
Улсын чанартай авто зам, замын байууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох судалгааны ажлын зардал	108,670.0	108,670.0	108,670.0	Зам тээврийн хөгжлийн төв	Шууд гэрээ
Улсын чанартай авто замын сүлжээний шинэ чиглэл тогтоох судалгааны ажлын зардал /ЗТХТөв/	46,610.0	46,610.0	23,305.0	Зам тээврийн хөгжлийн төв	Шууд гэрээ
Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний төлбөр авах цэгийн цахилгаан дамжуулах агаарын шунам барих зардал /ЗТХТөв/	14,810.0	14,801.9	14,801.9	“Амиргүй” ХХК	Харьцуулалт
А14 дугаартай Ховд-Булган-Улсын хил чиглэлийн замын төбөр авах цэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барих, үгсралт холболтын ажлын зардал /ЗТХТөв/	9,980.0	9,980.0			
“Авто замын төлбөр авах байр болон саравч зам талбайн тохижилт”-ын ажлын зураг төсөл, төсвийн ажлын зардал	9,780.0	9,780.0			
Хурдан морины уралдааны зам засварын ажил Хүй долоон худаг	49,200.0	49,200.0	48,648.3	“АЗТТТ” ТӨХК	Шууд гэрээ
1 дүгээр хавсралт дүн	3,656,020.0	5,194,499.8	3,612,395.2		
А0301 дугаартай УБ-Арвайхээр чиглэлийн авто замын 283-284 км у/м төмөр бетон гүүрэнд гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	661,500.0	661,500.0	654,590.7	“Эрдэнэсант А33А” ТӨХК	Шууд гэрээ
А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн авто замын 300-301 км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	88,900.0	88,900.0	88,859.7	“Хөвсгөл-А33А” ТӨХК	Шууд гэрээ
А1101 дугаартай Мөрөн-Хатгал чиглэлийн авто замын 3 болон 37 дахь км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	17,000.0	17,000.0	16,960.9	“Хөвсгөл-А33А” ТӨХК	Шууд гэрээ
А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн авто замын 91-95 км-т болон 130, 143-145 дахь км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	127,500.0	127,500.0	127,500.0	“Булган-А33А” ТӨХК	Шууд гэрээ
А0902 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн авто замын 6-26 дахь км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	54,800.0	54,800.0	53,712.4	“Орхон А33А” ТӨХК	Шууд гэрээ
А0602 дугаартай Хархорин-Цэцэрлэг чиглэлийн авто замын 15-20 дахь км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	24,300.0	24,300.0	23,779.8	“Хархорин А33А” ТӨХК	Шууд гэрээ
А0602 дугаартай Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 95-120 дахь					Шууд гэрээ

км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой	46,150.0	46,150.0	45,211.4	“Архангай АЗЗА” ТӨХК	
A1104 дугаартай Говь-алтай-Бургастай чиглэлийн авто замын 192-198 дахь км-т гарсан гэнэтийн эвдрэлийн онцгой ажил	158,000.0	158,000.0	157,999.8	“Говь-Алтай” ТӨХК	Шууд гэрээ
2 дугаар хавсралтын дүн	1,178,150.0	1,178,150.0	1,168,614.7		
НИЙТ ДҮН	4,910,985.2	6,445,438.1	4,852,528.3		

Дээрх ажлуудын гүйцэтгэлийг Зам, тээврийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсээс хянан Сангийн яаманд хүргүүлэн, санхүүжилтийн эрхийг нээлгэн тус тус гүйцэтгэгчдэд олгосон байна.

Сангийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн “Улсын төсвийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай” 342 тоот тушаалаар 4,498.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт 2017 оны 12 дугаар сарын 28-нд улсын авто замын сангийн дансанд орж, үлдэгдэлтэй гарсан байна.

Долоо. Дүгнэлт

Төлбөр хураах цэг /Автозамын сан/ нь үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж Улсын авто замын санд 19 төлбөр авах цэгээр дамжуулан 2016 онд 4,969.7 сая төгрөг, 2017 онд 7,006.9 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт тус тус төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган хэмнэлттэй зарцуулж, хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, тооцоог бодож, үр дүнг баталгаажуулан, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу орлогод авч, данс бүртгэлд тусган бүртгэж тайлагнаж ажилласан байна.

Авто замын тухай хуулинд Авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой зааснаас зөвхөн авто зам ашигласны төлбөрөөр сангийн эх үүсвэрийг бүрдүүлэн, хуулинд заасан бусад эх үүсвэрийг бүрдүүлэх нөхцөлийг ханган ажиллаагүй байна.

Сангийн эх үүсвэр нэмэгдсэнээр төлбөр авах цэгийн байршил нэмэгдэх, зам ашиглалттай холбоотой тээврийн хяналтын техник, тоног төхөөрөмжөөр хангагдах, зам засвар арчлалтын чанар, хүртээмж сайжрах, төлбөр хураагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг шаардлагатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх талаар хангалттай ажиллаагүй байна.

Төлбөр авах цэгийн замын сангийн орлого, үйл ажиллагааны зарлага санхүүжилт нь Төсвийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа боловч Төрийн өмчит үйлдвэрийн газрын дотоод бүтцэд нэгж хэлбэрээр ажиллуулж байгаа нь Авто замын сангийн бие даасан байдал алдагдаж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу үйл

ажиллагааг явуулж чадахгүй байна. Иймд Зам тээврийн хөгжлийн төв/ТӨҮГ/-ийн бүтцээс гаргаж бие даасан хуулийн этгээд /сан/-ийн хэлбэрээр ажиллуулах нь оновчтой байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР